# ХАА—н нэгдлүүдийн үйлдвэрлэлийн ашигт ажиллагааг улам нэмэгдүүлье

Саяхан тус аймгийн төвд аймгийн хөдөө аж ахуйн нэгдлийн зөвлөлийн II хурал болж «ХАА—н нэгдлүүдийн 1967 оны үйлдвэрлэлийн ажиллагааны дүн цаашдын зорилтын тухай» аймгийн ХАА-н Нэгдлийн Зөвлөлийн дарга Ч.Дашдэмбэрэлийн илтгэлийг авч хэлэлцэв.

ХАА—н нэгдлүүдийг өсгөн бэхжүүлэх талаар нам засгаас авч байгаа зүйл бүрийн арга хэмжээний үр дүнд нэгдлүүд өдрөөс өдөрт аж ахуй зохион байгуулалтын хувьд улам бэхжиж гишүүдийн аж амьдрал, соёлын хэмжээ дээшилсээр байна.

МАХН—ын Төв Хорооны 3 дугаар бүгд хурал, ХАА—н нэгдэлчдийн 3 дугаар их хурлын шийдвэрийг биелүүлэхэд тус аймгийн ХАА—н хоршоологчид их чармайлт гаргаж энэ онд мал өсгөх, хашаа барих, худаг гаргах, хадлан тэжээл бэлтгэх, малын ашиг шим ашиглах, төлөвлөгөөг жигд биелүүлэн зун намрын улиралд малдаа дээд зэргийн тарга хүч авахуулахаар нилээд ажлууд зохиож байна. Тус аймгийн ХАА—н нэгдлүүд эдийн засгийн хувьд бэхжиж нийгмийн үйлдвэрлэл хөгжсөний үр дүнд нэгдлийн дундаж хэмжээ өсч нэгдлүүдийн үндсэн хөрөнгө жил дутам 2,2 хувийн хурдацтайгаар өсөж түүний бүтцэнд чанарын их өөрчлөлт гарч үндсэн хөрөнгийн нийт өртгөнд үйлдвэр соёл ахуйн барилга байгуулалт трактор, комбайн авто ба ХАА—н машин техник тээврийн хэрэгслэл тоног төхөөрөмжүүд нилээд хэсгийг эзлэх боллоо. ХАА—н нэгдлүүдийн үндсэн хөрөнгө урьд жилээсээ 4,9 хувиар өссөний дотор барилга байгуулалт үржлийн ба ажлын мал, хөдөө аж ахуйн машин техник, авто машин, ердийн тээврийн хэрэгслэл 25,5—27 хувиар тус тус нэмэгдэж, үл хуваагдах фонд 3,1 хувиар өсчээ.

Сүүлийн жилүүдэд мал сүргийг тохилог дулаан хашаа саравч хүрэлцэх хэмжээний усаар хангахын тулд нилээд ажил зохиосны үр дүнд зөвхөн 1967 онд сүүлийн 2 жилд барьсан хашааны тоотой тэнцэхүйц хашаа саравч барьж нэгдлийн нийгмийн хээлтэгч хээлтүүлэгч мал үндсэндээ 2 ээлжийн хашаагаар хангагдаад байгаа ба 4,7 сая төгрөгийн үнэтэй өрөмдмөл ба энгийн уурхайн худагтай болж нэгдлүүдийн эзэмшилд байгаа бүх билчээрийн 2,4 сая га талбай усжуулагдаад байна.

Тэрчлэн гар ажиллагаа зонхилдог мал аж ахуйн хүнд хүчир ажлыг механикжуулж хөдөлмөр хөнгөвчлөх зорилгоор хонь хяргах, цахилгаан агрегат, үнээ гүү хонины цахилгаан саалтуур зэрэг орчин үеийн техник төхөөрөмж зарим нэгдлийн үйлдвэрлэлд нэвтэрч үр ашгаа өгч эхэлж байна.

Үүний зэрэгцээгээр газар тариалангийн үйлдвэрлэл амжилттай хөгжиж сүүлийн жилүүдэд хураажавсан ургацын хэмжээ 3,9 дахин, түүнээс орох орлого 14,7 дахин өсөж нэгдлүүд жилдээ олон тонн үр тариа улсад тушаадаг боллоо. ХАА-н нэгдлүүдийн эргэлтийн хөрөнгө ихээхэн өсч өөрийн эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрээр үндсэндээ хангагдаж гишүүдийнхээ аж амьдрал соёлын хэрэгцээнд зориулан туслах үйлдвэр, үйлчилгээний салбаруудыг хөгжүүлж ирсэн нь зохих үр дүнгээ өгч зөвхөн үүнээс жилдээ 4 сая гаруй төгрөгийн орлого олж байна. 1967 оны мөнгөн орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар Залуучуудын хөгжил, Бүрэндэлгэрэх, Сауул-амьдрал нэгдлүүд бусдаасаа илүү чармайлт гарган ажиллаж төлөвлөгөөгөө 0,2—5,8 хувиар давуулан биелүүлжээ. Мал аж ахуйн бригад суурьудад хөдөлмөр зохион байгуулалт хийсэн нь нэгдлийн гишүүд малчдыг хамтын хөдөлмөрт сургах тэднийг нийгмийн үйлдвэрлэлд үр бүтээлтэй ажиллах үлэмж боломжоо олгосны гадна хөлс төлөлт нилээд нэгдэлд ахицтай талууд гарч байна. Дэлгэрхаан сумын «Залуучуудын хөгжил», Баянжаргалан сумын «Шинэ амьдрал» зэрэг нилээд нэгдлүүд нийгмийн аж ахуйгаа бэхжүүлэх нэгдэлээ хөгжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх талаар зохистой арга хэмжээ авч байгаагаас үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөгөөр төлөвлөгдсөн зүйлүүд үндсэндээ биелэгдэж ашигт ажиллагаа нэмэгдэж байна.

Гэвч ХАА—н нэгдлүүдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хөдөлмөр зохион байгуулалт муу, аж ахуйг жинхэнэ эдийн засгийн мэдлэгтэйгээр удирдах явдал ХАА—н нэгдлүүдэд хангалтгүй байгаа явдлыг нэгдлийн зөвлөлийн гишүүн Х.Балжинням Б.Насанжаргал, Л.Банзрагч, П.Сумхүү нарын 20 шахам хүн тодорхой баримтаар ярив.

Манай олонх нэгдлүүд өөртөө байгаа дотоод нөөц боломжоогоо ашиглахгүй төлөвлөгөөг жигд биелүүлэхийн төлөө санаачлага муутай ажиллаж ирснээс мөнгөн орлогын төлөвлөгөө ихээхэн хэмжээтэй тасарсан байна. ХАА-н нэгдлүүд 1967 оны жилийн мөнгөн орлогын төлөвлөгөөг 10,8 хувиар тасалдуулсны дотор МАА-гаас орох орлого 10,0 хувиар, газар тариалангаас орох орлого 11,7 хувь, туслах үйлдвэрээс орох орлого 14,6 хувиар тус тус тасарсан байна.

Монгол—Польшийн найрамдал», «Баян—амьдрал», «Хэрлэн баян» зэрэг нилээд нэгдлүүд орлогынхоо төлөвлөгөөг 14,4-32,5 хувиар тасалжээ. ХАА-н нэгдлүүдийн нэгжээс ашигласан ашиг шимийн байдал, 100 хээлтэгчээс бойжуулсан унага тугал бойжуулалт доогуур байгаа ба «Заамар» нэгдэл ботго 14, «Хэрлэн баян» нэгдэл унага 28, «Ялалт» нэгдэл тугал 38, «Улаанбаатар» нэгдэл хурга 62-ыг тус тус хүлээн авч бойжуулсан нь нэгдлийн дунджаас 19—23 төлөөр доогуур бойжуулж мал өсгөх асар их боломжоог алджээ. Нэг малаас авч ашиглах ашиг шимийн байдал нэгдэл тус бүрийд харилцан адилгүй байгаа явдал бол мал сүргийн эрүүлжилт, тарга хүч, малын арчилгаа маллагаа хүмүүсийн ажиллагаа ажлын хариуцлага, бүртгэл тооцоо хяналт шалгалт хир зэрэг байгаатай холбоотой юм.

Нэгдлүүдэд трактораар гүйцэтгэсэн ажлыг бүртгэх түүний зардлын бичилт үнэн зөв хийгдэхгүй байгаагаас трактораар гүйцэтгэсэн ажлын 1 га—д зарцуулсан зардал нэгдэл бүрт харилцан адилгүй өөр байна.

Алтанбулаг сум нэгдэлд 9 төгрөг 53 мөнгөөр бүртгэсэн байхад Баяндэлгэр сум—нэгдэлд 15 9 төгрөг 50 мөнгөөр бүртгэгдэх жишээтэй байна. ХАА—н нэгдлүүдэд байгаа авто машины ашиглагдвал зохих бүх машины 62,7 хувийг ашиглаж 10,1 мянган машин өдөр ашиглагдаж чадаагүй байна. ХАА—н нэгдлүүдэд төлөвлөлтийн чанар муу, төлөвлөгөөний систем аж ахуйн бүх салбарт, жигд нэвтэрч үйлдвэрлэлийг чиглүүлэн удирдах дайчин зэвсэг болж чадаагүй, үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөг баримтлаж ажиллахгүй, үйлдвэрлэлийн салбаруудад хөтлөгдвөл зохих анхан шатны бүртгэл зохих ёсоор хөтлөгдөхгүй тайлан баланс цаг хугацаандаа зөв гарахгүй, түүнд дүн шинжилгээ хийгдэхгүй байна.

ХАА—н нэгдлийн нийгмийн мал жигд сайн өсөхгүй байгаа нэг шалтгаан бол малын хээл хаялт, сувайралт их хэмжээтэй байгаа ба өвчин ба зүй бусаар жилдээ олон тооны мал хорогдуулж байгаагаас болж байна.

Нэг малаас авах ашиг шим, га—гаас авах ургац бага, улсын бэлтгэлд бэлтгэж байгаа зүйлийн чанар муу, түүнд чанарын заслага хийхгүй үхсэн малын арьс, шир, үс ноос, өөх тос, яс авч ашиглаж даггүйгээс орлогын асар их нөөц боломжоо алдаж байна. Нэгдлүүдэд хөдөлмөр өдөр чухал үүрэг гүйцэтгэж ирсэн ба гүйцэтгэсээр байгаа боловч хөдөлмөрийн зарцуулалтыг зөв хэмжих, хөлсний хэмжээг тодорхой харуулах, хөлсний тооцоог хөнгөн шуурхай болгох бие үйлдэхүүнийг зөв хуваарилах явдалд нилээд дутагдал оршиж байгаа ба хөлс олголтын дэвшилттэй хэлбэр мөнгөн хөлсний системийг нилээд нэгдэл одоо болтол хэрэглэхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн улирал жилийн тайлан балансыг хавсралт үзүүлэлтээр нь тогтоосон хугацаанд нь чанар сайтай үнэн зөв гаргах, бүртгэлийн бичилт тайлан баланс зохиолтын ажиллагаанд соёлжилтыг бүрэн нэвтрүүлж бүртгэлийн материалыг зохих зааврын дагуу эмх цэгцтэй хадгалах, эд хариуцагчдын тооцоог улирал дутам бодох ажлууд шаардлагын хэмжээнд хүрч чадаагүй байна. Заамар сумын «Заамар» нэгдэл зарим няравуудын тооцоог сүүлийн 3—5 жилд бодоогүй ба 1967 оны жилийн эцсийн тайлан баланс гаргахдаа нэгч няравын тооцоо бодолгүй гаргасан байна.

Үйлдвэрлэлийн ажиллагаанд бүртгэл тооцоогоор тавих хяналт шалгалт сулаас болж зарим нэгдлүүдэд үйлдвэрлэлийн зардлыг буруу бүртгэх үйлдвэрлэл ямар замаар явж байгааг олж харахгүй, ашиг алдагдлаа ч нарийн тооцож чадахгүй байгаа ба зарим нэгдлүүд зээлийн хөрөнгийг зориулалттай зүйлд нь үр ашигтай зарахын оронд цаг үеийн шаардагдсан зориулалтгүй зүйлд зарцуулах явдал ч үзэгдэж байна.

МАХН—ын Төв Хорооны бүгд хурал, ХАА—н нэгдэлчдийн III их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэн биелүүлж ХАА-н нэгдлүүдийн биеэ даасан байдлыг хангаж, нэгдэл нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж төлөвлөгөөт даалгаврыг хугацаанд нь биелүүлэх, удирдлагын хариуцлагыг дээшлүүлж үйлдвэрлэлийн үр ашгийг мөнгөөр тооцож орлогоороо зарлагаа нөхөж, аж ахуйг ашигтай ажиллуулах нөхцлийг хангасан төлөвлөгөөтэй удирдах явдал чухал болж байна. ХАА—н нэгдлүүдийн улирал дутмын тайлан балансад хийх эдийн засгийн шинжилгээ судалгааг чанаржуулан нэгдлийн үйлдвэрлэлийг бэхжүүлэх, банкны зээлийн хэмжээг зөв тогтоож ашиглалтыг сайжруулан, фондын шимтгэл байгуулж хоорондын тооцоонд бэлэн мөнгө хэрэглэхийг эрс багасгаж бэлэн бус тооцоог тууштай нэвтрүүлж өр авлагыг барагдуулах явдал чухал байна. Хөдөө аж ахуйн нэгдлүүдийн авто ба ХАА-н машин техникийн ашиглалтын коэфицентийг дээшлүүлж түүнийг аятай гамтай эдлэж эвдрэлийг багасгаж цөөн тооны машинаар их хэмжээний ажил үүрэг гүйцэтгэж чадахаар зохион байгуулахаас гадна түүнд тавих хяналт шалгалт, даац ашиглалт, төлөвлөгөөжүүлэлт бүртгэл тооцоог сайжруулж ажиллах хэрэгтэй. Нэгдлийн орлогыг нэмэгдүүлж үйлдвэрлэлийн ашгийг сайжруулахад нэгжээс ашиглах ашиг шим, га-гаас авах ургацыг нэмэгдүүлж хонь, ямаа, гүү, ингэний сүү саах, үхсэн малын үс ноос, арьс шир, өөх тос, яс боловсруулах хэсгүүдийг зохион байгуулан ажиллуулж аж ахуйн төхөөрөмж, ажиллах хүч, орон байр, уналга тээврээр хангаж өгөхөөс гадна нэгдлийн нийгмийн аж ахуйд гарч байгаа элдэв гарз хохирлыг аль болохоор багасгахын төлөө тууштай ажил зохиох хэрэгтэй болж байна. Малын өсөлт хөгжилт ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэхэд шийдвэрлэх нэг асуудал бол усаар хангах явдал мөн.

Нэгдлийн Зөвлөлийн хуралд ХААН—ийн Холбооны Дээд Зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга н.Рэнцэнсэнгээ, аймгийн Намын Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ш.Агваансодов, Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дарга Ц.Жамсран нар оролцож, н.Рэнцэнсэнгээ, Ц.Жамсран нар ХАА—н нэгдлийг аж ахуй, зохион байгуулалтын талаар бэхжүүлэх, цаашдын зорилтыг тодорхойлж дэлгэрэнгүй үг хэлэв.

Хариуцлагатай эрхлэгч Н.МӨНХӨӨ

(Х—00025) «АНХДУГААР ТАВАН ЖИЛ» СОНИНЫ ҮЙЛДВЭРТ ХЭВЛЭВ.

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн

# Анх дугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо,
А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

21 дэх жилдээ
№ 45 (1734)

1968 ОНЫ
6 ДУГААР САРЫН 20

ПҮРЭВ

# Барилгын ажил нийт ард түмний үйл хэрэг

МАХН—аас барилга байгуулалтын ажлыг нийт ард түмний үйл хэрэг болгон дэвшүүлэн тавьж барилгын материал техникийн баазыг хөгжүүлэх, аж ахуй зохион байгуулалтын талаар бэхжүүлэх мэргэжилтэй боловсон хүчнээр хангахад чиглэсэн олон талын арга хэмжээ авсаар байна.

Тус аймагт 1963 оноос хойш улсын барилгын байгууллагын шугамаар 13,2 сая төгрөгийн барилга угсралтын ажил хийсний дотор 1967 онд Жанчивлингийн рашаан сувиллын нэгдсэн барилга, 12 худалдагчтай дэлгүүр, барилгачдын 12 айлын сууц, Намын Хорооны барилгын өргөтгөлийг дуусгаж ашиглалтанд оруулснаар жилийн барилга угсралтын төлөвлөгөөг 2 сарын өмнө давуулан биелүүлж гялалзсан амжилт гаргасан юм.

Аймгийн улс ардын аж ахуйг хөгжүүлэх 1968 оны төлөвлөгөөгөөр барилга байгуулалтын ажилд нийтдээ 3,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт зориулсан бөгөөд үүнээс улсын барилгын байгууллагаар барилгачдын 12 айлын сууц. нийтийн 24 айлын сууцыг дуусгаж нэгдсэн больницын барилга барихад 2,1 сая төгрөгийн ажил хийх болно.

Гэтэл барилга конторын ажилчдын тоо, машин техникийн хүртэлцээ өнгөрсөн оныхоос дутуугүй байгаа хир нь энэ жилийн эхний таван сард гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын хэмжээ урьд оны энэ үеийнхээс 34,5 хувиар доогуур байна.

Барилгын ажлын хөдөлмөр зохион байгуулалт муугаас болж ажлын сул зогсолт их гарч хөдөлмөрийн бүтээлд муугаар нөлөөлж байна.

Нийт барилгачдын ялангуяа техник мэргэжлийн ажилчдын идэвх санаачлага ажлын хариуцлага жигд биш байна.

Захиалагч байгууллагын зүгээс тавих шаардлага оролцох оролцоо ихээхэн хөндий байгаа ба аж ахуйн аргаар барьж буй барилгын явц аль ч талаасаа бүр ч хоцрогдонгуй байна.

1967 онд Өнжүүл суманд тэн дэхийн нам захиргаа, аж ахуйн байгууллагын хүсэлт, хүч болол цоонд тулгуурлан сум дундын эмнэлгийн барилга барих хөрөнгө улсаас өгсөн боловч хэдхэн машин тоосго татаж авсанаас өөр ямар ч ажил хийлгүй үлэмж хөрөнгө түгжиж өнгөрөөгөөд энэ онд бүтэн 6 сарын хугацаа өнгөрөөд байхад нэг ч төгрөгийн ажил хийгээгүй улсын барилгын төлөвлөгөөг мөн л тасалдуулж байна.

Энэ бол гүйцэтгэгч «Ялалт» нэгдлийн зөвлөл, захиалагч аймгийн Эрүүлийг Хамгаалах газрын хариуцлагагүй ажиллагаанаас болж байгаа хэрэг мөн.

МАХН—ын Төв Хороо 1963 онд «Барилга байгуулалтын ажил бол нийт ард түмний үйл хэрэг мөн» гэсэн сэдвээр «Үнэн» сонины бага хурал хийлгэж барилга байгуулалтын ажлыг гагцхүү нийт ард түмний үйл хэрэг болгон анхаарсан цагт энэ ажлыг манай орны хөгжлийн шаардлагын хэмжээнд хүртэл өөд татаж болно гэж заасны дагуу барилга байгуулалтын ажлын ач холбогдол, барилгын тэргүүний байгууллага, хүмүүсийн туршлага, гарсан шинэ бүтээл, оновчтой саналуудыг тал бүрээс нь сайн сурталчилж эзэмшүүлэх, хөрөнгө материалыг арвилан хэмнэж бүртгэл тооцоог сайн зохион явуулах нь чухал байна.

Барилга байгууламжийн орон нутгийн нөөц материалыг аль болох өргөн хэрэглэх, барилга барилтын хугацааг түргэтгэх, барилгын ажлын эдийн засгийн бүх үзүүлэлтийг сайжруулах явдал шаардагдаж байна.

Барилгын дэргэдэх нам, олон нийтийн байгууллагууд улсын төлөвлөгөөт объект нэг бүрийн ажлын явц, ажиллах хүчний зохион байгуулалт, материал техникийн бэлтгэл, хангамж, машин механизм ашиглалт зэргийг байнга нягтлан хянаж, барилгын төлөвлөгөө биелүүлэх бүх талын арга хэмжээг урьдаас авдаг байх хэрэгтэй.

Их барилгын ажлыг нийт ард түмний үйл хэрэг болгон хөдөлмөрчдийг барилгын ажлын мэдэгдэхүүнд сургах, ажилчин албан хаагчдыг барилгад зохион байгуулалттай ажиллуулахад ихээхэн анхаарал тавих хэрэгтэй юм.

Барилга байгуулалтын ажлыг үндсээр нь сайжруулах талаар Намын Төв Хорооны 1963 оны V бүгд хурлын заалтыг хэрэгжүүлэн биелүүлэх хэрэгт манай нам, улс, олон нийтийн бүх байгууллага нийт хүмүүс онцгой анхаарч ажиллах явдал чухлаар шаардагдаж байна.

**Аймгийн намын XIV бага хурлын өмнө**

# Намын Хорооны бүх гишүүдийн хурал

Баянчандманий Намын Хорооны бүх гишүүдийн хурал 1968 оны 6 дугаар сарын 10—нд болж, аймгийн Намын Хорооны сүүлийн 2 жилд хийсэн ажлын тайланг аймгийн Намын бүгд хурлын гишүүн Дарамсүрэн, сэхээтнүүдийн ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах тухай илтгэлийг Намын Хорооны нарийн бичгийн дарга Цогбадрах нар тавьж хэлэлцүүлэв.

Илтгэлтэй холбогдуулан 11 хүн үг хэлэв.

Үг хэлсэн хүмүүс аймгийн Намын Хорооны зохион байгуулалтын удирдлага зөв байсныг сайшаав.

Сумын аж ахуйн төлөвлөгөөт ажлаас эхний 5 сард бэлтгэлийн 32 нэр төрлийн зүйл 100—гаас дээш хувиар, хөөвөр, хялгас, ноолуур 101—103 хувь, малаас гарсан төл 97 хувь бойжиж буй зэрэг ахиц байгаа боловч, ажилтны ажлын хариуцлага сахилга бат суларснаас үйлдвэрийн төлөвлөгөөг таслах, чанар муутай бүтээгдэхүүн гаргах мал аж ахуйн ажиллагаанд тавих хяналт шалгалт суларчээ. Жишээ нь: Засварын газар дээр ажилтны ажлын хариуцлага сахилга бат муу байгаагаас төлөвлөгөө тасалдах, бүтээгдэхүүний чанар муу, малын билчээрийг сонгон олж нутаглах ба байгалийн ямар нэгэн гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахгүй мал аж ахуйн үйлдвэрлэлийг удирдах арга барил муу байснаас 5 дугаар сарын сүүлчээр орсон бороо цаснаар засварын газар 120 гаруй мал, үржил станц 280 гаруй хонь хорогдуулсан зэргийг тодорхой баримтаар шүүмжлэв.

Тус хурал хэлэлцсэн асуудлын тухай тогтоол гаргав.

Энэ хурлаас МАХН—ын гишүүн Жигжид, Дэлгэрмаа, Галзагд, аймгийн Намын Хорооны 2 дугаар нарийн бичгийн дарга Дамбажамц нарыг аймгийн намын XIV бага хурлын төлөөлөгчөөр сонгов.

С.Бямбаа

# *Намын үүр хороодын бүх гишүүдийн хурлын дүн*

Аймгийн намын XIV бага хурлыг угтаж аймгийн Намын Хорооны 2 жилийн ажлын тайланг Намын анхан шатны үүр хороодын бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлсэн ба бага хурлын төлөөлөгчдийг сонгосон дүнг аймгийн Намын Хороо гаргав. Энэ дүнгээс үзэхэд аймгийн Намын Хорооны 2 жилийн ажлын тайланг хэлэлцэхэд аймгийн намын бүх гишүүд орлогчдын 78,1 хувь нь оролцож намын бага хурлын төлөөлөгчдийг 100 хувийн дүнтэй сонгосон байна.

Бага хурлын төлөөлөгчдөд хонь таргалуулалтын аймгийн 3 удаагийн аврага Т. Ширчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Долгор, БНМАУ-ын аврага төлчин Нямдаваа, Гачууртын САА—н тэргүүний саальчин Догоо—Аюуш нарын зэрэг тэргүүний ажиллагаатай намын гишүүд сонгогджээ.

Намын үүр, хороодын бүх гишүүдийн хурлын санал шүүмжлэлээс үзэхэд аймгийн Намын Хорооноос тайлангийн хугацаанд зохиож явуулсан ажлыг намын бүх анхан шатны байгууллагуудын хурал зөв зарчим, чиглэлтэй явагдсан гэж санал нэгтэй сайшаажээ.

Аймгийн намын бага хурлыг угтаж эрхэлж хариуцсан ажил дээрээ тодорхой амжилт бүтээл гаргаж 1968 оны эхний хагас жилийнхээ төлөвлөгөө нормыг давуулан биелүүлэх үүрэг амлалтыг намын олон арван гишүүд, орлогчид авсан байна.

Аймгийн Намын Хорооны тайлангийн хугацааны ажилд боловсон хүчнийг хүмүүжүүлж тогтвор суурьшилтай ажиллуулах талаар намын анхан шатны байгууллагууд хангалтгүй ажилласан, залуу үеийг хүмүүжүүлэх, социалист өмчийг хайрлан хамгаалах, дотоодын нөөц бололцоог ашиглах талаар далайцтай ажил зохиогоогүй, олон нийтийн байгууллагуудын бие даасан ажиллагааг хангалтгүй удирдаж байсан ба СХБ ба СХТБ-ын ажлыг тал бүрээс нь дэмжиж түүний хөдөлгөөнийг өрнүүлэх ажлыг тодорхой удирдаагүй дутагдал аймгийн ҮЭ—ийн зөвлөлд байна гэжээ.

Мөн аймгийн хэмжээний соёл урлагийн ажил, хүн эмнэлгийн эмчилгээ үйлчилгээ, харилцаа холбооны ажил, МХЗЭ-ийн үүр хороодын дотоод ажил жигд сайжирч чадаагүй.

Сүүлийн жилүүдэд малын хариуллага, манай малчдын малд тавих анхаарал суларч байгалийн гэнэтийн аюулд мал олон толгойгоор хорогдох явдал байсныг намын олон гишүүд тодорхой баримтуудаар нотлон шүүмжилсэн байна.

Аймгийн Намын Хороо, тайланд гарсан санал шүүмжлэлийн мөрөөр ажиллах төлөвлөгөө хийж, сум нэгдэл, САА үйлдвэр албан байгууллага, хүмүүстэй холбогдсон шүүмжлэлийг төрөлжүүлэн нэгтгэх, аймгийн намын XIV бага хурлын илтгэл шийдвэрүүдэд тусгах арга хэмжээ авч байна.

Намын хорооны зохион байгуулагч Д.Бадарч

# Аймгийн ҮЭ—ийн Зөвлөлийн IV бүгд хурал

6 дугаар сарын 17-нд аймгийн ҮЭ—ийн Зөвлөлийн IV бүгд хурал Зуунмод хотод болов.

Бүгд хуралд бүгд хурлын гишүүд, клуб улаан булангийн эрхлэгчид, төвийн албан үйлдвэрийн газрын дарга, эрхлэгчид оролцов. Хуралд «ҮЭ-ийн улс төр, соёл хүмүүжлийн ажлын үр нөлөөг дээшлүүлье» гэсэн илтгэлийг аймгийн ҮЭ—ийн Зөвлөлийн дарга Д.Лувсандорж тавьж хэлэлцүүллээ.

Илтгэгч: Манай оронд социализм төгс байгуулах өрнүүн хөдөлмөрийн үед Үйлдвэрчний Эвлэлийн байгууллагын соёл олон түмний ажлын шаардлага улам их болж хүрээ нь өргөжсөөр байна.

Улс төр, соёл хүмүүжлийн ажлыг дээшлүүлэх явдал бол үйлдвэрийг эрчимжүүлж, байгаа нөөц бололцоог зөв зохистой ашиглаж, бага зардал гаргаж их бүтээгдэхүүн үйлдвэрлэж үйлдвэрийн ашигт ажиллагааг сайжруулах жинхэнэ хэрэглүүр мөн.

Монголын Үйлдвэрчний Эвлэлийн IX их хурал «Нийгмийн гишүүдийн улс төр, ёс суртахуун, соёл үйлдвэрлэл, техникийн боловсролыг дээшлүүлэх нь ҮЭ—ийн соёл хүмүүжлийн ажлын гол зорилт мөн» гэж заасан юмаа.

Аймгийн намын 3 дугаар бүгд хурал олон нийтийн байгууллагын ажлыг сайжруулах тухай шийдвэр гаргасан билээ. Энэ зорилт шийдвэрүүдийг биелүүлэхэд аймгийн ҮЭ-ийн байгууллагууд нилээд ажлыг зохиож ирлээ.

Соёл олон түмний ажил нь зөвхөн тоогоор биш, гагцхүү чанар, үр дүнгээр хэмжигдэнэ.

—Аймгийн ҮЭ—ийн Зөвлөл жил дараалан улс төр соёл хүмүүжлийн ажлын явц, үр нөлөөг дээшлүүлэх тухай асуудлыг идэвхитний хурал, тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж заалт шийдвэр гаргаж биелэлтийг шалгах ажлыг зохиож ирлээ.

Ажилчин албан хаагчдын улс төр, ерөнхий боловсрол, үйлдвэрлэл, техникийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, ажилчны клуб улаанбулан, кино, номын сан зэрэг соёлын салбаруудын материаллаг баазыг бэхжүүлэх талаар үргэлжийн удирдлага туслалцаа өгч байна.

Спартакиад, уулзалт, экскурс, аялал зугаалга зэрэг олон хэлбэрт ажлууд зохиогдож байна.

1967-68 оны хичээлийн жилд нийт ажилчин албан хаагчдын нилээд нь ҮЭ-ийн байгууллагын системээр гэгээрлийн ажилд хамрагдав.

Клубь улаанбулангуудын дэргэд хүүхдийн ба насанд хүрэгчдийн бүлгэм секц 78 ажиллаж байна.

Аймгийн хэмжээгээр материаллаг үйлдвэрлэлд ажиллагсадын 50,4 хувь нь тусгай мэргэжилтэй, 60,1 хувь нь ерөнхий боловсролтой болжээ.

Сүүлийн 2 жилд тэргүүний ажилчдын тоо 61,7 хувиар өсч, ажлаараа хоцрогсодын тоо 8 хувиар хорогдов.

Ажилчид, инженер техникчдийн 90 гаруй хувь нь социалист уралдаанд хамрагдаж социалист хөдөлмөрийн бригад нөхөрлөлийн тоо 7,5 хувиар нэмэгдлээ.

Аймгийн ЭХ Газар, Жаргалантын САА, Зуунмод хотын артель зэрэг албан газрууд улс төр, соёл гэгээрлийн ажлыг нилээд системтэй сайн явуулж байна.

Гэвч улс төр, соёл хүмүүжлийн ажлын үр нөлөөг дээшлүүлэхийн ач тусыг дутуу үнэлж энэ ажилд хайнга хандах явдлууд зарим ҮЭ-ийн байгууллагууд дээр үзэгдсээр байна.

Жишээ нь: Угтаалын САА, Эрдэнэсантын МААМС—ын дэргэдэх ҮЭ—ийн хороо улс төр, соёл гэгээрлийн ажлыг хангалтгүй зохиож иржээ.

Нийгмийн гишүүдийн улс төр, ёс суртахуун, соёл үйлдвэрлэл техникийн боловсролыг дээшлүүлэхэд зохион байгуулалтын удирдлага шийдвэрлэх үүрэгтэй.

Цаашид улс төр соёл хүмүүжлийн ажилд тооцоо судалгаа нэвтрүүлэх, соёл хүмүүжлийн ажилд гүйцэтгэлийн шалгалт явуулах үр нөлөөг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбон дүгнэх, энэ ажилд тэргүүн туршлага нэвтрүүлэх гэсэн гурван үндсэн чиглэлийг удирдах зохион байгуулах ажлын үндэс болговол зохино.

Техник мэргэжлийн дугуйлангаар заалгасан зүйлийн үр дүнг ажилчдын бүтээсэн зүйл, санаачлага, тэргүүний арга барилтай харьцуулан дүгнэж байх, 1970 оны наана 16—45 насны хүмүүсийг анхан шатны боловсролтой болгон ажилчид албан хаагчдад хөдөлмөрийн эрх, төр эрх зэрэг хуулийн мэдлэг эзэмшүүлнэ.

Ардын хувьсгалын 50 жилийн ойг угтаж 1969 оны 6 дугаар сард аймгийн спартакиадыг зохион явуулах төлөвлөгөөг боловсруулна.

Төвлөрсөн газруудад сард нэг удаа радио бага хурлыг хийж, ололт дутагдлыг хэлэлцэж, лекцийн суртал нэвтрүүлгийн ажлыг хүмүүсийн нас, ажил төрлийн онцлогт тохируулан төрөлжүүлж нийт хөдөлмөрчдийг бүрэн оруулж байх нь зүйтэй.

Үйлдвэр барилга, ХАА-н байгууллагууд ажилчдын ерөнхий боловсрол, техник мэргэжлийн талаар 2—3 жилийн программ боловсруулж, 1968 оны хичээлийн жилээс эхлэн хичээллэх нь чухал байна гэлээ.

Бүгд хурлын гишүүн Батчулуун, Ж. Дулмаа, Дүгэрсүрэн, Б.Доржсүрэн нарын 20 шахам хүмүүс үг хэлэв.

Бүгд хурлын гишүүд аймгийн Үйлдвэрчний Эвлэлийн байгууллагын улс төр соёл хүмүүжлийн ажлын далайц сул ялангуяа хөдөлмөрчдийн дотор хуулийн ба шашингүйн сурталнэвтрүүлгийн ажил зохиох, төр эрхийн талаар мэдлэг олгох ажил хангалтгүй байна.

Хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх ажилд албан байгууллага, нийгмийн гишүүд бүр жигд оролцохгүй өөрсдийн биеэр үлгэрлэх асуудал дутагдалтай байгааг тодорхой баримттай шүүмжлэн ярив.

Хуралд аймгийн АДХГ Захиргааны дарга Ц.Жамсран, Намын Хорооны хоёр дугаар нарийн бичгийн дарга Дамбажамц, Монголын ҮЭ—ийн Төв Зөвлөлийн Соёлын хэлтсийн эрхлэгч Цэнд нар оролцож үг хэлцгээв.

Бүгд хурлаас цаашдын ажлын чиг, арга барилыг заасан тодорхой тогтоол гаргалаа.

**Манай сурвалжлагч**

## Өвс хадлангийн бэлтгэл

Баян сумын АДХГ Захиргааны 8 дахь удаагийн 3 дугаар чуулган саяхан болж, өвс хадлангийн бэлтгэл ажлын талаар депутат Цэнд, ХАА—н байнгын комиссын дарга, депутат Насан нарын илтгэлүүдийг хэлэлцэж сумын АДХГ Захиргааны дарга Агванчүлтэмээр удирдуулсан өвс хадлангийн ажлыг удирдах сумын комиссыг байгууллаа.

Чуулганаас хадланд механикжсан бригад 1, морин машин 35, морин тармуур 17, 110 морь 480 хүн оролцуулж 3150 тонн өвс авахын хамт суурьудад шимт тэжээл, тарваганы ходоод, таана, агь, хар хомоол түүх зэрэг тодорхой даалгаврыг өгч хадланг 45 хоногт дуусгаж хадсан өвсөө өвөлжөө, хаваржаанд бүрэн татаж хамгаалах зохион байгуулалтын арга хэмжээ авахаар заалаа.

**С. Бурмаа**

## НӨӨЦ БОЛОЛЦОО

Нийгмийн үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар МАХН-аас дэвшүүлж байгаа зорилтыг тууштай хэрэгжүүлэх нэг нөхцөл бол нийт үйлдвэрлэл, байгууллагын дотоод нөөц бололцоо, байгалийн баялгийг илрүүлэн ашиглах явдал мөн.

Нөөц бололцоог илрүүлж бүрэн ашиглах явдал албан үйлдвэр, аж ахуйн газрууд, нам, захиргааны болон олон нийтийн байгууллагын зохион байгуулалтын удирдлага, эзэмдэн ажиллах аж ахуйч сайн ажиллагаа, идэвхи санаачлагаас голлон шалтгаалах болно.

Манайд ашиглаж чадвал маш их нөөц байна.

Зуунмод хотын Нийгэм Хангамжийн товчоо жил дутам олон мянган тонн нүүрсний үнсийг байшингийн дээврийн дулаалгаас өөр зүйлд төдийлөн хэрэглэлгүй хаягдал болгож байсныг өөрчилж уг үнсийг буталж нунтаглан элс цементтэй хольж малын хашаа барих санаачлага гаргаад ажиллаж байгаа нь урьдчилсан тооцоогоор нэг хашаанаас 3-4,0 мянган төгрөгийн цэвэр ашиг олохоор харагдаж байна.

Тэгвэл Зуунмод хотын 12 уурын зуухны 10 шахам мянган тонн үнсийг бүрэн ашиглаж чадвал хичнээн их төгрөгний хуримтлал олж болох нь тодорхой байна.

Гэвч дотоод нөөц бололцоог бүрэн ашиглах талаар манай байгууллага, хөдөлмөрчид бүр жигд биш анхаарч байна.

Аймгийн хэмжээгээр жил дутам 110 мянган мал идшинд хэрэглэж нилээд мал зүй бусаар хорогдож байна.

Үүнээс зөвхөн ясны ашиглалтын тооцоог гаргахад нэг тэмээнээс 12-15 кг, нэг адуу, үхрээс 10-12 кг, нэг богоос 2 кг яс ашиглана гэж үзвэл жилд доод зах нь 700—гаас доошгүй тонн яс бэлтгэх бололцоотой байна.

Гэтэл тус аймаг жил бүр дөнгөж 300-гаад тонн яс л улсын бэлтгэлд нийлүүлж байгаа юм.

Мөн манай аймаг, сумын төвийн хөдөлмөрчдийг сүү айраг, цагаан идээгээр хангах бололцоог олигтой ашиглахгүй байгаагаас болж, сүү, сүүн бүтээгдэхүүнээс орох асар их орлого хуримтлахгүй үрэгдэж байна.

Сүү нийлүүлэх үүрэг хүлээсэн ХАА—н нэгдлийн үнээний тоо, түүний сүүний гарцаас үзэхэд төв суурин газрын хөдөлмөрчдийг сүүгээр хангах бүрэн хүрэлцээ нөөцтэй байгаа боловч үнээний хээлийг зөв зохицуулан бүрэн төллүүлж, үнээний сүүг нэмэгдүүлэх тууштай арга хэмжээ авахгүй, тугалтай үнээ бүрийг саалинд саах зохион байгуулалтын ажил үнэхээр дутагдалтай байгаа зэргээс улсад сүү нийлүүлэх төлөвлөгөө тасалдаж байна.

Саасан сүү нь ч жинхэнэ улсын төлөвлөгөөт үүргийг биелүүлж, хөдөлмөрчдийн хэрэгцээг хангахад биш хувийн журмаар борлогдох явдал гарч байна.

Түүнчлэн зарим үйлдвэр, аж ахуйн газруудад машин техникийн хүчин чадлыг ашиглах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, өөрийн өртгийг хямдруулах асар их нөөц бололцоо байгаа боловч түүнийг илрүүлэн дайчилж ашигладаггүй дутагдал их байна.

Зуунмод хотын ҮХ—ын артельд 1964 онд модны комплект станокууд авчирч тохеөрөмжлөн тавьсан боловч түүний хүчин чадлын 50 хүрэхгүй хувийг ашиглаж, модон эдлэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг хэдэн жил дараалан тасалдуулж байна.

Тээврийн авто машины ашиглалт ч нийт газруудад тун хангалтгүй байгаа юм.

Энэ бүхнээс үндэслэн эх орондоо социализмын материал техникийн баазыг байгуулах явдалд манай нам, улс, олон нийт, үйлдвэр аж ахуйн байгууллагууд өөрийн дотоод нөөц, орон нутгийн бололцоог бүрэн илрүүлж гүйцэт ашиглах талаар гол анхаарлаа чиглүүлэх нь нэн чухал болж байна.

Тэгэхдээ ямар нөөц бололцоо байгаа, түүнийг яаж ашиглах вэ? гэдгийг урьдаас сайн тооцож сайн зохион байгуулахад онцлон анхаарах хэрэгтэй.

Үйлдвэрлэлд гарч байгаа шинэ санаачлага, тэргүүн туршлагыг дэмжих үндсэн дээр үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, ашиглагдаагүй нөөц бололцоог илрүүлэн ашиглах явдал чухал юм.

Мэргэжлийн хүмүүс ажилчин олны санал зөвлөлгөөг байнга сонсож тэдний санаачлагыг өрнүүлэх социалист уралдааныг жинхэнэ ёсоор зохион байгуулах нь нөөц бололцоог ашиглахад чухал түлхэц болох бөгөөд энэ ажилд бүх нийтээрээ хүч анхаарлаа дайчлан ажилласнаар эх орныхоо материаллаг баялгийн хуримтлалд зохих хэмжээний хувь нэмэр оруулж чадна гэдгийг анхаарах хэрэгтэй байна.

**С.Дондогдорж**

# Т ү м н и й х у р ц х а р а а

## Санхүүгийн хяналт шалгалтыг сайжруулъя

Санхүүгийн хяналт шалгалтыг тогтмол чанартай хийж хөрөнгийн арчлалт, зарцуулалтыг сайжруулан бүртгэл тооцоог нарийн чанд болгосноор нийгмийн өмчийг үрэгдэл шамшигдлаас бүрэн хамгаалж чадна. Үйлдвэрлэлийн ажиллагааны жинхэнэ үр дүн нь нийгмийн хөрөнгийг х и р зэрэг хэмнэлттэй зарж, төгрөг мөнгө тутмаас олох үр ашгийг аль хир нэмэгдүүлж, социалист хуримтлалыг яаж арвижуулж байна гэдгээр харагдахаас биш зөвхөн улсын төлөвлөгөөг яаж биелүүлэв, хэд хичнээн төгрөгийн бүтээгдэхүүн гарав гэдгээр хэмжигдэх асуудал биш юм.

Үйлдвэр аж ахуйн газруудад явуулах санхүүгийн хяналт шалгалтыг заавал санхүүгийн хэлтэс, хянан байцаах тасгаас явуулж байх ёстой биш, үйлдвэр аж ахуйн газрууд дотооддоо санхүүгийн хяналт шалгалт хийх үүрэгтэй юм.

Аймгийн санхүүгийн хэлтэс оны эхэнд үйлдвэр аж ахуйн газруудад өөрийн системийн байгууллагатаа хяналт шалгалт явуулах төлөвлөгөө өгсөн байна.

Гэтэл дотооддоо явуулбал зохих хяналт шалгалтыг ЭХ газар, ХБУ газрын санхүүгийн байгууллагууд хангалтгүй хийж байна. ХБУ газар, ХБ—ийн 12 ангийн санхүүд шалгалт явуулахаас одоо дөнгөж 4, ЭХ газар бага эмчийн 15 салбарт санхүүгийн шалгалт явуулахаас хагас жил өнгөрч байхад дөнгөж хоёры нь шалгасан байна.

Үүнээс дүгнэлт хийхэд байгууллагын дотооддоо явуулах хяналт шалгалтыг уг төлөвлөгөөний дагуу чанартай сайн явуулах нь чухал.

Үүгээр ч үл барам аймгийн санхүүгийн хэлтэс ХБУ газартай хамтран ХБ—ийн 6 анги, нэгдлийн зөвлөлтэй хамтран 2 нэгдлийн санхүүд хяналт шалгалтыг явуулахаар төлөвлөөд нэгий нь ч одоо болтол эхлээгүй байна.

Санхүүгийн дотоодын хяналт шалгалт сулаас үйлдвэр аж ахуйн газрын үлэмжхэн хөрөнгө үр ашиггүй зарагдаж аж ахуйч биш ажиллагаа газар авч байна.

Жаргалантын САА-н 10 жилийн дунд сургууль (захирал нь Төмөрсүх) 1967 оны төсвөөс 20 гаруй мянган төгрөгийг хэтрүүлэн заржээ.

Мөн сурагчдаар концерт тоглуулсан, Жаргалантын САА-н усжуулахад газар шорооны ажил хийлгүүлсэн, хүүхдийн хоолны хэрэгцээнээс илүү гарсан махыг борлуулсан, актласан эд хогшил худалдсан зэргээс улс, аймгийн орлогод оруулбал зохих 7000 гаруй төгрөгийг багш Жадамба, Гүндэгмаа, Бунтар, аж ахуйн захирал Цэдэн-Иш нарын гар дээр байлгаж хүмүүсийн хувьдаа хэрэглэх үрж шамшигдуулах үүд хаалгыг нь нээн өгч байжээ. Сургуулийн захирал Төмөрсүх өөрийнхөө хэрэгцээнд 1967 онд сургуулиасаа үхэр 1, хонь 4—ийг худалдан аваад түүний үнэ 1267 төгрөгийг одоо болтол төлөөгүй улс нийгмийг хохируулсаар байна.

Энэ мэт зүйлс тус сургуулийн аж ахуй санхүүгийн үйл ажиллагаанд нилээд байсан нь шалгалтаар илэрчээ.

Санхүүгийн байгууллагуудын гол зорилт бол үйлдвэр аж ахуйн газруудын санхүүгийн үйл ажиллагааг шалгаад тавьсан актынхаа биелэлтэнд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг тогтмол явуулж байх явдал юм.

Гэтэл тавьсан актынхаа мөрөөр ажил зохиодоггүй дутагдал аймгийн санхүүгийн хэлтэс, хянан байцаах тасагт амь бөхтэй үргэлжилсээр байгаад зохих дүгнэлт хийх хэрэгтэй. Энэ оны эхээр аймгийн Намын Хорооны товчоо санхүүгийн хяналт шалгалтыг сайжруулах арга хэмжээний тухай гаргасан тогтоолдоо санхүүгийн шалгагч, байцаагч нарын ажлын арга туршлагыг хооронд нь солилцуулах, семинар зөвлөлгөө өгөх, санхүүгийн холбогдолтой хууль дүрмийг судлуулахаар заасан заалтыг тун хангалтгүй биелүүлж байгаад зохих дүгнэлт хийж тэдний шалгах арга чадварыг дээшлүүлэх талаар далайцтай ажлыг зохиох нь зүйтэй байна. Үйлдвэр аж ахуйн газруудын үйл ажиллагаанд эдийн засгийн дүн шинжилгээг тогтмол хийж МАХН—ын Төв Хорооны III бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхэд аж ахуйн салбарт анхан шатны тоо бүртгэл, тооцоо хэрхэн нэвтэрч байгаа, тайлан балансын дүн ямар болсонд намын байгууллага байнга хяналт тавьж судалгаа дүгнэлт хийж ажиллах хэрэгтэй.

Б. Балгансүрэн

## Өр дутагдалтай шийдвэртэй тэмцэе

Социалист нийгмийн оршин тогтнох, цаашид хөгжин бэхжихийн үндэс бол нийгмийн социалист өмчийг хайрлан бэхжүүлэх явдал мөн.

Иймд МАХН энэ талаар онцгой анхаарч, ардын хувьсгалын үе шат бүхэнд тусгай хууль тогтоомж гаргаж түүнийг хэрэгжүүлэн биелүүлж социалист өмчийг үрэгдүүлэгч жавшигчидтай шийдвэртэй тэмцлийг явуулж ирсэн юм.

Манай орны хөгжлийн нрээдүйд хоршоолол олон нийтийн өмч хөрөнгө нь улсын өмч буюу нийт ард түмний хөрөнгө болж улмаар нэгдмэл социалист өмч болон хөгжих ёстой юм. Энэ учраас социалист өмчийг хайрлан арвижуулах үндсэн арга нь юуны өмнө түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулах цаашид тайлан тооцоог тухай бүрт нь үнэн зөв явуулж, социалист өмчинд тавих хяналт шалгалтыг тогтмол чанартай болгох, энэ чанараараа нийт иргэдийг социалист өмчинд эзний ёсоор хандаг болгон хүмүүжүүлэх хэрэгтэй.

Үүний зэрэгцээгээр нийгмийн ариун дархан өмчинд хохирол учруулсан буруутай хүмүүст захиргааны, сахилга батын, олон нийтийн арга хэмжээ авах, түүнчлэн социалист өмчинд аж ахуйч бишээр хандагчдад хууль зүйн хариуцлага хүлээлгэхийн хамт тэдэнтэй мөнгөөр тооцох тооцоог нэн өндөрт тавих нь чухал юм.

1968 оны 1 дүгээр улирлын байдлаар аймгийн нийт ХАА-н нэгдлүүд оны эхэнд байсан байгууллага хүмүүсээс авах авлагаа 3,5—4,8 хувиар бууруулж үүний дотроос Өнжүүл сумын «Ялалт» нэгдэл 21,7 хувь хүртэл багасгасан байхад Баяндэлгэр сумын «Хэрлэн баян», Эрдэнэсант сумын «Саруул амьдрал» нэгдлүүд оны эхэнд байсан авлагаа 1,2—47 хувиар нэмэгдүүлжээ.

Үүний гадна Заамар нэгдлийн санхүү өр авлагаа барагдуулах талаар нилээд зүйл хийсэн хир нь эд аж ахуйн нярав Дашдэндэв, шатахууны нярав Лувсангомбо нарын тооцоог сүүлийн 4 жилд бодоогүй явж ирсэн ба 1967 онд нэг ч эд гардагчдын тооцоог бодоогүй байна.

Тус аймгийн зарим үйлдвэр, албан газарч хоорондын өр авлага дуусгах талаар муу анхаарч байна.

Аймгийн Харилцаа холбооны газар «Хэрлэн баян» нэгдэлд оны эхэнд 7000 гаруй төгрөгийн өртэй байсан бол үүнээ дуусгалгүй дээр нь 10000 төгрөгийн өр нэмсэн зэрэг дутагдал илэрч байгаад дүгнэлт хийж албан үйлдвэр, хоршооллын байгууллага, хүмүүс хагас жилийн тайлан балансын өмнө өглөг авлагаа тооцон дуусгаж, санхүү данс тооцооны ажилтан бүр эд хариуцагчдыг тооллого тооцоонд чанартай бэлтгүүлэн тооцоогий нь бодож тайлан балансдаа үнэн зөв үзүүлэлт гаргах явдал чухал байна.

З. Батсүх

## *Шалгалтын үр дүн*

Аймгийн намын 4 дүгээр бүгд хурлаас социалист өмч хөрөнгийг хайрлан хамгаалж арвижуулан дотоодын нөөц бололцоог дээд хэмжээгээр ашиглахын чухалыг онцлон заасан билээ.

Худалдааны байгууллагын дэргэдэх нам төрийн хяналтад туслах ОНХШ комисс, бүгд хурлын шийдвэрийг биелүүлэхийн тул дотоод нөөц бололцоог хэрхэн ашиглаж байгаад шалгалтынхаа ажлыг чиглүүлж байна.

Хотын худалдааны ангийн тээврийн ба тусгай зориулалт бүхий нийт машины 1967 оны ашиглалт, зарцуулсан зардлын байдалд э н э оны эхээр ОНХШ комиссын гишүүд, ня—бо, жолооч нарын бүрэлдэхүүнтэйгээр шалгасан шалгалтын дүнгээс үзэхэд тээврийн машиныг сул явуулах, үл ялих сэлбэг хэрэглэлээр дутагдаж олон хоногоор ажилгүй зогсоох, нэг хийх юмыг 2 дахин хийх, бага зардал гаргах зүйлийг их зардлаар хийх, шатахууныг тооцоо муутай олгох, машин техникийг хайр гамгүй эдлэж хүч чадлыг дутуу ашиглах зэрэг үндсэн дутагдлууд оршиж байсан нь илэрлээ.

Үүнээс болж өнгөрсөн 1967 онд тээврийн авто машины 75 хувь нь 9006 төгрөг 42 мөнгөний алдагдалтай ажиллажээ.

Улаанбаатар хот, сумдаас бараа татахдаа бололцоог ашиглан ачаатай явуулах талаар санаа тавьж ажиллаагүй нь уг дутагдлын голлох шалтгаан болжээ.

Шалгалтын дүнгээс тус ХБ—ийн ангийн захиргаа зохих дүгнэлт хийж зарим авто машины эвдрэлийг засаж, сул зогсолтыг арилган ашиглалтад оруулж тээврийн машин бүрийг хоёр талдаа ачаатай явуулах, шатахууны тооцоог сар дутам бодох журам тогтоож, жолооч нарын ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилга батыг дээшлүүлэх талаар нилээд ажил зохиосны үрээр энэ оны эхний 5 сарын байдлаар нийт машин 6574 төгрөгний ашигтай ажиллаа.

Гэвч удирдах хүмүүсийн зөвшөөрөлгүй хэрэглэх, сул явуулах, зохих байранд нь тавихгүй гаднаа тавих зэрэг дутагдал бас л бүрэн арилж чадаагүй үргэлжилсээр байгаад зохих дүгнэлт хийж ажиллах явдал шаардагдаж байна.

Улс, олон нийтийн өмч хөрөнгийг үрэгдүүлэн шамшигдуулах, үр ашиггүй зарцуулахын өчүүхэн төдий илрэлүүдтэй эрс тэмцэх нь манай хянан шалгах байгууллага, иргэн бүрийн ариун үүрэг мөн.

Худалдааны байгууллагын дэргэдэх нам төрийн хяналтад туслах ОНХШ комиссын дарга Авид

## НЭГ ШАЛГАЛТЫН ДҮН

Жаргалантын САА—н ХЗЭ—ийн хорооны хянан шалгах пост нь ОНХШ комисстой хамтран хаврын тариалалт, хөрс элдэншүүлэлт тариа хордуулалт, цэвэрлэлтийн ажилд тогтмол хяналт тавин ажилладаг байна. Жишээ нь: хянан шалгах постоос САА—н «хар эрэг» үтрэмийг шалгасан байна.

Э н э шалгалтаар 217 тонн «Сратов 29» сортын буудай намар буусан янзaараа байсныг илрүүлэн тодорхой хугацаанд цэвэрлэн арчилах үүрэг өгч ажилласнаар уул буудайг зохих хугацаанд нь цэвэрлэсэн байна. Мөн ажилчдын хөдөлмөр, цаг ашиглалтыг шалгахад 2 сар гаруй хугацаанд 50 хүн 114 өдөр буюу 910 цагийн хөдөлмөр тасалсан байсныг илрүүлэн зохих хүмүүст арга хэмжээ авсан байна.

Тариалангийн машин техникийн засвар үйлчилгээ, запас хэрэгслэлийг шалгаж үзэхэд зарим машин техник запас байхгүй нэрийдлээр сул зогсож байсан ба үүнийг судлан үзэхэд олгогдвол зохих 320 гаруй төгрөгийн запас олгогдоогүй байсан зэрэг дутагдлуудыг илрүүлэн газар дээр нь арга хэмжээ авч ажиллаж байсан байна.

Д. Сумъяа